

# Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

# АНХАГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 68 (2372)

1974 оны 9 дүгээр сарын 12

ПҮРЭВ

## ОЙН БАЙГУУЛЛАГЫН 50 ЖИЛИЙН ОЙ

МАХН, ардын засгийн газраас үндэсний аж үйлдвэр, ажилчин ангийг бий болгох эх орны байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаар авсан анхны хувьсгал арга хэмжээний нэг нь мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрийг байгуулж аж ахуй зохион байгуулахын хувьд бэхжүүлж хөгжүүлсэн явдал юм. Мөн түүнчлэн ой агнуурын баялгийг хайрлан хамгаалж, өсгөн үржүүлэх, зохистойгоор ашиглах үүрэг бүхий ойн анги, модон материалыг төвлөрсөн журмаар үйлдвэрлэх улс ардын аж ахуйн салбарыг хөгжүүлэх, ард түмний хэрэгцээг хангах мод буй болгох, ард түмний хэрэгцээг хангах мод боловсруулах үйлдвэрүүд байгуулснаас хойш түүхэн хөгжлийн хагас зуун жил өнгөрч байна.

Улсын анхдугаар хурлаар байгуулагдсан Аж ахуйн яаманд ой агнуурын асуудал эрхэлсэн хэлтэс ажиллуулж Нийслэл хүрээ, Онон, Ерөө голын орчимд ойн ангиуд байгуулсан нь ойн байгууллагын эх үүсвэр байлаа.

Ойн байгууллага үүсч хөгжсөн үеэсээ эхлэн ойгоос мод тавьж олгох, гоожин түрээс хураах, нүүрс давирхай бэлтгэх ажлыг батлагдсан дүрмээрээ зохицуулан ажиллаж улс орны ой, агнуурын баялгийг хамгаалан хямгадах, зөв ашиглах, ой модыг аясаар нь ургуулах, арчилан хамгаалахад бүхий л үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж ирлээ.

Манай нам, засгаас ойн байгууллагыг байнга анхааран хөгжүүлсээр ирсэн бөгөөд үүний тод жишээ нь тус аймагт 1972 онд модон эдлэл үйлдвэрлэх 3 тасагтай, ой, ан хамгаалагч 34-тэй нийтдээ 100-гаад ажилчинтай ойн байгууллагыг тус аймгийн байгалийн бүх баялгийг хамгаалж ашиглахыг зохицуулах түүнд хяналт тавьж байх үүргтэй байгуулсан юм.

Тэр жилдээ 1200,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй ажиллан ойн орлого, дагалт ашиглалтын төлөвлөгөөг 27—35 хувиар давуулан 41 мянган төгрөгийн ашигтай ажиллаа.

1973 онд Ойн аж ахуйн байгууллага өргөжиж 317,5 мянган төгрөгийн төлөвлөгөө хүлээн авч нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн жилийн төлөвлөгөөг 126 хувь, ойн орлогын төлөвлөгөөг 133,9 хувиар бие хувь, ойн орлогын бүтээмжийг 17 хувиар дээшлүүлэн өөрийн өртгийг 3 хувиар хямдруулж, 340 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, бараа борлуулалтын төлөвлөгөөг 103 хувиар биелүүллээ.

Үүний үр дүнд эхний хагас жилд аймгийн үйлдвэр аж ахуйн газрууд дотроос 2 дугаар байр, жилийн эцэст яам салбарын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Хороо, аймагтаа 3 дугаар байранд тус тус орж жуух, диплом, баярын бичиг 5—10 мянган төгрөгөөр шагнагдлаа.

1974 он гарсаар сар бүрий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тогтмол давуулж ирлээ.

Үүний дүнд эхний хагас жилийн төлөвлөгөөг 110,1 хувь, ойн орлогын төлөвлөгөөг 193,6 хувиар биелүүлж хөдөлмөрийн бүтээмжийг 5,5 хувиар дээшлүүлэн, өөрийн өртгийг 2,8 хувиар хямдруулсан зэрэг амжилтаар их ойгоо угтлаа.

Цаашид төлөвлөгөөт зорилтоо жигд чанарын өндөр үзүүлэлтээр давуулж ирэх оноос үржүүлгийн талбайтай болох зорилтыг тавин ажиллаж байна.

### Төлөвлөгөөг давуулан биелүүлээ

Бүрэн сумын бүрэлдэгчээр нэгдлийн хадланчид хадлангийнхаа төлөвлөгөөг 9 дүгээр сарын 6-ны байдлаар 103,1 хувиар биелүүлж 500-гаад тоннныг нь өвчтөж харваржаанд татаж нөөцлөөд байна.

Ц. МАЖИГСҮРЭН

Дун сумын «Энх туул» нэгдлийн «Цагаан уул» бригадынхан төлөвлөгөөт 500 тонн өвсөө 9 дүгээр сарын 1-ний байдлаар бэлтгэж дуусаад 80 гаруй хувийг нь нуруулаадаа байна.

Г. МЯСМАР

ДЭЛГЭРХААН СУМЫН НАМЫН ҮҮРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С. ЦЭНД, СУМ-НЭГДЛИЙН ДАРГА Л. МОЛОМ НАРТ.

Энэ оны улсад бэлтгэх тосыг 12,6, эвдэмцэрийг 2,4 хувиар хураанаас нь өмнө давуулан биелүүлж сөйхон амжилт гаргасан манай сумын нийт хөдөлмөрчид, ажилчид, олон нийтийн байгууллага, залуучуудын хөгжил нэгдлийн зөвлөл, бүх гишүүдэд халуун баяр хүргэж улс ардын аж ахуйн төлөвлөгөөт бусад амжилтаар их амжилт гаргана гэдэгт аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа бат итгэж байна.

Аймгийн Намын хорооны пэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.АДЫАА

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч.ДАШДЭМБЭРЭЛ

## Аймгийн АДХГ Захиргаа, ҮЭ-ийн Зөвлөлд

Саяхан аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөлийн хавсарсан хурал болж тус аймгийн үйлдвэр, ХАА, Тээвэр, Холбоо, Соёлын байгууллагаас V таван жилийн төлөвлөгөөг хураанаас нь өмнө биелүүлсэн хүмүүст V таван жилийн гавшгайг тэмдэг, мандат олгох тухай хэлэлцлээ.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөлийн хавсарсан хурал V таван жилийн төлөвлөгөөг тоо чанарын өндөр үзүүлэлтээр 3 жил 10 сараас 1 жил 6 сарын өмнө биелүүлсэн Жаргалантын САА-н тракторч, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар М.Чойжамц, Ц.Дугарсүрэн, Угтаалын САА-н тракторч комбайнч Г.Алтанхүү, Батсүмбэрийн САА-н ногоочин, Я.Должинжав, мөн САА-н саальчин Ц.Хорлоо, Баянцогтын САА-н тракторч комбайнч Д.Очир, Батсүмбэрийн САА-н саальчин Н.Амаржаргал, Баяндэл-

гэр сумын кино механикч Д.Доржгоцоо, Өндөрширээт сумын хадланч, улсын аварга Н.Болд, Эрдэнэсант сумын хоньчин П.Базаррагчаа, Т.Сүрэнхүү, Баянцогтын холбооны салбарын эрхлэгч А.Гомбо, аймгийн Холбооны газрын шуудан тасгийн ялагч Ш.Цэрэнханд, УААУГ-ын жолооч Гончигсүрэн, БУК-ын барилчигчин Г.Бор нарын зэрэг 145 хүнд V таван жилийн гавшгайг тэмдэг, мандат олгохоор тогтов.

## УРГАЦ ХУРААЛТ—ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ

Хадлан тариа ногоо хураалтын үе дэх хөдөлмөр хамгаалалт нь хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчлөх, механикжуулах, техник технологийг боловсронгуй болгох, ажилчин иж нэр техникийн ажилтнуудын хууль эрх, хөдөлмөр хамгааллын мэдлэгийг дээшлүүлэх, аюулгүй ажиллагааны арга барилын дүрэм заавруудын шаардлагыг бүрэн биелүүлэх, осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авах явдал билээ.

Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл хадлан, тариа, төмс, хүнсний ногоо хураах компани ажил эхэлхийн өмнө сум нэгдэл, САА-нуудын дарга, инженер, агрономчдын үйлдвэрлэлийн зөвлөлтөөн, семинар зохиож техник механизмын хаалт хамгаалалт, анхааруулга санамж дохиог бүрдүүлж, ажилчид, жолооч, техникчдийг аюулгүй ажиллагааны арга барилд сургах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар үзүүлэх сургууль, хичээл зааж, албан даалгавар, лекц ярианы сэдэв, зөвлөмж боловсруулан гаргаж мөрдүүлж байна.

Батсүмбэр, Жаргалантын САА, Архустын ТАА ургац хураалтын үе д ажилчдыг аюулгүй ажиллагааны арга барилд сургах, аюулгүй ажиллагааны 3 шатны зааварчиг аянгуула ажилын байрны болон давтан зааварчиг чанартай өгч хүн бүр дээр хяналт бүртгэлийн хуудас хөтөлдөг болж ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэлтэй бүрэн олгож, ажлын явцад өмсч хэрэглэж хэвчлүүлэх, тех-

ник механизмын хаалт хамгаалалт анхааруулга санамж дохиог бүрэн хийх, талбайд хөдөлмөр хамгааллын эргүүл пост ажиллуулдаг болжээ.

Архустын ТАА жолооч техникч нэг бүртэй төлөвлөгөөт даалгаврыг биелүүлэх, осол гэмтэлгүй ажиллах талаар гэрээ байгуулан ургац хураалтанд ажиллах комбайн бүрийг шалгаж хаалт хамгаалалт нигжээсийг бүрэн хийж, комбайнчдад аюулгүй ажиллагааны зааварчиг аянгуула өгсний дараа талбайд ажиллахыг зөвшөөрсөн гэрчилгээ олгох зэрэг ажлуудыг хийдэг болсны үр дүнд сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлтэй холбогдсон осол гэмтэл гараагүй байна.

Жаргалант, Борнуурын САА ургац хураалтын үед хөдөлмөр хамгааллын булан кабинет байгуулж тэндээ хөдөлмөрийн эрүүл ахуй, гоо зүй, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, түүнийг өмсөж хэрэглэх журам, аюулгүй ажиллагааны анхааруулга санамж дохио тэмдгүүд, галын аюулаас сэргийлэх арга, осол гэмтэл тохиолдох үед анхны тусламж үзүүлэх талаар самбар үзүүлэн хийж үүнээс гол зүйлүүдийг ургацны штаб бригадуудад тавьж хөдөлмөр хамгааллын ажлыг сурталчилж байна.

Гэвч ургац хураалтын үеэр үйлдвэрлэлтэй холбогдсон осол гэмтлээс, хөдөлмөр хамгааллыг сайжруулах ажил жигд биш, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны арга барилын дүрмийг зөрчсөнөөс үйлдвэрлэлтэй холбогдсон осол гэмтэл жил тутам гарч байгаа

явдалд орон нутгийн нам, захиргаа, ҮЭ-ийн байгууллагууд дүгнэлт хийж тодорхой ажил зохиох нь чухал.

Урьд жилүүдэд ургац хураалтын үеэр гарч байсан осол гэмтлийн гол нь хөдөлмөр зохион байгуулалт муу, аюулгүй ажиллагааны арга барилын дүрэм зааврыг зөрчсөн, машин механизмын хаалт хамгаалалт, дутуу, үйлдвэрлэлийн технологийн дараалал буруу, бүрэн биш техникийн ажилд гаргасан зэргээс шалтгаалж байжээ. Энэ жилийн ургац хураалтын явцад хөдөлмөр хамгаалал аюулгүйн техникийн дүрэм заавруудын биелэлтийг аймгийн 10 гаруй сум-нэгдэл, САА түүний тасаг бригадуудад шалгаж үзэхэд зарим газар өнгөрсөн жилүүдийн дутагдал дахин давтагдаж байна.

Баянзүрх сумын «Сүхбаатарын зам», Баяндэлгэр сумын «Хэрлэн-баян», Мөнгөнмөр с у м н «Улаанбаатар», Баянжаргалан сумын «Шинэ-амьдрал» зэрэг нэгдлүүдэд нэгдэл-сум, нэгдлийн ҮЭ-ийн зөвлөлийн хооронд хөдөлмөр хамгааллын хэлцлээр байгуулаагүй байна. Хадлан ургац хураалтанд ажиллаж байгаа ажилчид, жолооч техникчдэд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлгүй олгоогүй, дутуу олгосон ажлын явцад өмсөж хэрэглэж хэвшүүлэх, хуучин хувцас хэрэгсэлийг угааж засварлах талаар ажил зохиогоогүй байгаа дутагдал ихэнх нэгдэл, зарим САА-нуудад үзэгдэж байв.

Баяндэлгэр, Эрдэнэсант,

(Төгсгөл нь II цүүрт)

## УРГАЦ ХУРААЛТ- хөдөлмөр хамгаалал

Тогсгол. (Түрүүч  
нь I нүүрт)

Лүн, Баянзүрх зэрэг нилээд сумдын хадлан тариана ногоо хураалтанд ажиллаж байгаа техник механизмуудыг шалган үзэхэд хаалт хамгаалалт, гэрэлтүүлэг дутуу, анхааруулга санамж дохио хийгдээгүй байлаа.

Ургац хураалтын үед осол гэмтэлгүй ажиллах нэг нөхцөл нь үтрэмийн машинуудыг чанартай засварлаж, хаалт хамгаалалтыг бүрдүүлэх, цахилгаан тоноглолуудын газардуулгыг зөв хийх, үтрэмийн талбайг хүрэлцээтэй гэрэлтүүлэх, оюутан сурагчид, ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчлаа өгөх явдал юм.

Гэтэл Эрдэнэ, Мөнгөнморьт, Баянжаргалан зэрэг сум—нэгдлүүдэд ургац хураалтын ажил эхлээд байхад үтрэм, үтрэмийн машинуудыг засварлаж дуусаагүй, үтрэмийн гэрэлтүүлэг, цахилгаан шугамуудыг засварлаагүй байлаа.

Тракторын чиргүүд, өндөр ачаан дээр хүн суулгаж тээвэрлэх, тракторын кабинд нормоос илүү хүн суулгах явдал Угтаал, Борнуурын САА, Эрдэнэсантайн ТАА, Баянзүрх, Эрдэнэ сумын нэгдлүүд дээр гарч байна.

Хадлан тарианы бригад, салаа, хүмүүсийн хооронд социалист уралдаан өрнүүлэх уралдаанд үүрэг амлалт авахуулахдаа хөдөлмөр хамгаалал осол

гэмтэлгүй ажиллах талаар тодорхой тусгахгүй, уралдааныг дүгнэхэд энэ чухал үзүүлэлтийг орхигдуулж байгаа дутагдал олонхи САА, ХАА-н нэгдлүүдэд гарсаар байна.

Зарим сум—нэгдэл, САА-н нам, захиргаа, олон нийтийн байгууллагуудаас хадлан тариа, ногоо хураалтанд ажиллаж байгаа ажилчид, оюутан сурагчид, жолооч техникчдийн дунд зохиох суртал ухуулгын ажил хангалтгүй ялангуяа хөдөлмөр хамгаалалтын хууль тогтоомж аюулгүй ажиллагааны дүрэм заавруудыг сурталчлан таниулах ажил сул байна.

Ажилчид, оюутан, сурагчид, жолооч техникчдийн орон байр тохилог бус, хоолны амт чанарыг сайжруулж, нэр төрлийг олшруулах, хоолонд ногоо, сүү, цагаан идээ хэрэглэх явдал хангалтгүй байна. Иймд дээрх дутагдалд дүгнэлт хийж, хадлан тариа, ногоо хураалтын үед хөдөлмөр хамгаалалтын хууль тогтоомж аюулгүй ажиллагааны дүрэм заавруудыг ширхэгчлэн биелүүлж ургацыг богино хугацаанд хаягдалгүй, чанартай хурааж явдал чухалчлагдаж байна.

Хөдөлмөр хамгаалалтын улсын байцаагч  
**Ш. БАТТУЛГА**  
«Үнэн» сонин  
сурвалжлагч  
**О. СУМБЯА**

## КОММУНИЗМЫН ОРНЫ АЛХАМ

### ЗХУ-ын ойн аж ахуйн хөгжилт

ЗХУ-д дэлхийн бүх ой модны бараг дөрвөний нэг нь байдаг.

Мод болон модноос боловсруулж авдаг олон мянган бүтээгдэхүүнгүйгээр тэр бүр үйлдвэрлэл явагддаггүй юм.

Ой бол ус хадгалагч, талбай хамгаалагч, уур амьсгалыг зохицуулагч, газрын амьсгалагч нь болдог юм.

ЗХУ 1,2 миллиард гаталбай ойн, 80 миллиард кубметр модны нөөцтэй юм. ЗХУ-ын ойд бүтэн хагас мянган үүлдрийн мод сөөг ургагдгийн гадна дэлхийн үнэт мод шил мүүсийн нөөцийн тэн хагасаас илүү нь ноогдож байна.

Модноос 30,0 мянган төрлийн бүтээгдэхүүн гарган авч байна.

ЗХУ-ын орон нутагт ой

хамгаалах ойн ажил эрхэлдэг 2400 гаруй аж ахуй, 11,0 мянгад ой хамгаалагчид ажилладаг. Өнгөрсөн таван жилд 11 сая 200 мянган га газрын ойг сэргээжээ.

Энэ таван жилд 12,0 сая га газрын ойг сэргээж, 1,3 сая га газрын ойг хатаана.

1973 онд 2,3 сая га газрын ойг сэргээсний дотор 1,3 сая га талбайд мод тариалж, суулгасны үрээр хамтрал, САА-н намаг, гуу, жалга, элс зэрэг 245,0 мянган га талбайн хөрснийг бэхжүүлэн ойжуулжээ.

Байгалийн гамшиг гантай тэмцэх арга хэмжээнүүдийг чухалчлан төмдлэсэн «Гантай тэмцэх тухай» засгийн газрын тогтоолд 1921 оны IV сард В. И. Ленин гарын үсэг зуржээ.

### ОЙН ГАЙХАМШИГ

Ой мод бол шим мандлыг хамгаалагч, амрах, зугаалах газар, эрүүл мэндийн эх сурвалж юм.

Ой улс ардын аж ахуйн чухал салбарыг хөгжүүлэх түүхий эдийн бааз билээ.

Модноос хамгийн наад зах нь 3 түмэн нэр төр-

лийн бүтээгдэхүүн гарган авна.

ЗХУ-д наян тэрбум орчим шомо метр модны нөөц бүхий 747 сая га ой бий.

ЗХУ, энэхүү өгөөмөр баян ойн баялгаа ямагт зохиистой ашигладаг.

Зөвхөн ЗХУ-ын эсэж цаасны үйлдвэрийн ажилт

Одоо Комышаас Волгоград, Белградаас Дониин эрэг хүртэл олон мянган километр улсын ойн зурвас үргэлжилж байна.

Мод бэлтгэлт, модон материал үйлдвэрлэлтээр ЗХУ дэлхийд 1 дүгээр байр эзлэж байгаагийн дээр мод бэлтгэлт сүүлийн 25 жилд бараг 2 дахин өсч одоо жил тутам 400 сая гаруй шоо метр мод бэлтгэж байна.

1974 онд Зөвлөлийн дорнод мужид мод бэлтгэлт улам ихээр өснө.

Гадаадад гаргах мод 2,5 сая шоо метрээр нэмэгдэнэ.

Модыг дахин сайтар боловсруулж хаягдал ашиглаж модон материалын нөөцийг 20 сая гаруй шоо метрээр нэмэгдүүлнэ.

Кортон, целлюз, цаасны үйлдвэрлэл 8,4—2,5 хувиар өснө.

Усть—Чилимны целлюлоз—цаасны хүчирхэг заводыг ЭХХТЗ-ийн орнуудын хамтарсан хүчээр барих хэлэлцээ хийгджээ.

**Н. ХАНДСҮРЭН**

нууд 1974 онд 6100 мянган тонн эсэж, 4908 мянган тонн цаас, 2984 мянган тонн хатуу цаас үйлдвэрлэнэ.

Энэ бол ойн гайхамшигын үзүүлэлт юм.

Ойн энэ гайхамшигийг эрхлэн ажиллагч хүмүүсийн дотроос алдар цуутай сайчууд олноор төрж, эл хөдөлмөрийн гайхамшигийг улам өндөрт өргөдөг юм.

## БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАЯ

**Х. ДАМДИН** (Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч дарга)

Манай орны улс ардын аж ахуйн бүх салбарын түргэн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг бүрэн хангахад байгалийн нөөц баялгийг хамгаалж зохиистой ашиглан, түүнийг нөхөн үйлдвэрлэлийг хангах явдал асар их ач холбогдолтой билээ.

Иймээс эх орны байгалийн бүх баялгийг орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшилд зохицуулан ашиглахын хамт түүнийг өсгөн арвижуулах нь манай иргэн бүрийн эрхэм үүрэг мөн.

Манай аймагт жил тутам эх орны болон экспортын хэрэгцээнд ойн баялаг, агнуурын аж ахуйгаас нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээ, зарим төрөл нэмэгдэж, эдгээр баялгийг олзворлох дэвшилттэй арга нэвтэрч байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганы шийдвэрийн дагуу манай аймгийн хэмжээгээр зохион явуулсан байгаль хамгаалах дөрвөн удаагийн сарын ажил нь иргэн бү-

рийн байгалийн тухай мэдлэг, байгалийн баялгийг хайрлан хамгаалж зохиистой ашиглах, хүрээлэн байгаа орчныг цэвэр арчун байлгахад зохих үр дүнгээ үзүүлэхийг арга хэмжээ болов.

Энэ ажлын явцад чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх, байгаль ан амьтдыг зохиистой ашиглах талаар тодорхой төлөвлөгөө гарган ажиллаж суртал нэвтрүүлгийн олон талт ажил аймгийн хэмжээгээр нилээд эрчимтэй зохиож зохих үр дүнд хүрсэн байна.

Гэвч байгалийн нөөц баялгийг хайрлан хамгаалж зохиистой ашиглахад тавих анхаарал жигд сайжрахгүй, байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг зөвхөн авч ашиглах үүрэгтэй мэт ойлгох явдал байсаар байгаагаас ойн дагалт баялаг жимс, самар, сонгино зэргийг боловсруч гүйцээгүй байхад түүх, мод сөөгийг хугалж гэмтээн сүйтгэх, дархан цаазтай ан амьтдыг хуулийн хугацаа бо-

лоогүй байхад агнаж устгах зэрэг хууль зөрчих явдал арилаагүй байна.

Зарим хүн анхаарал болгоомжгүйгээс гал алдан үлэмж хэмжээний ой, хадлан, бэлчээр түймэрт хөнөөгдөж, улс нийгэмд их хирол учруулах зэрэг дутагдал оршоор байна.

Иймд байгалийг хамгаалах, түүнийг нөөц баялгийг зохиистой ашиглахын ач холбогдол, энэ талаар нам, засгаас тавьж байгаа бодлого шийдвэрийг хөдөлмөрчдөд байнга сурталчлах ажлыг эрчимтэй зохиохын зэрэгцээ байгаль хамгаалах талаар гарсан хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт шалгалтыг хүчтэй болгож элдэв зөрчлөн гарахаас урьдчилан сэргийлэхийн хамт гарсан зөрчлийг тухай бүр илрүүлэн засч байх нь чухал юм.

БНМАУ-ын Ардын Их Хурлын VI чуулганаас ой, ан амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх ажилд байгууллага, иргэн

бүр хувь нэмрээ оруулахыг уриалж байгалийн нөөцийг арвижуулах, үр бүтээлтэй ашиглах, ялангуяа байгаль хамгаалах ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх тухай заалтыг хэрэгжүүлэх нь манай өнөөгийн хойшлуулшгүй зорилт болж байна.

Байгаль хамгаалах 5 дахь удаагийн сарын ажил энэ 9 сарын 15-наас орон даяар эхэллээ.

Байгаль хамгаалах энэ удаагийн сарын ажил нь урьдын адил байгууллага иргэн бүрийн байгальтай харьцах харьцааг сайжруулах, хөрс, ургамал, ой, ан амьтдыг хамгаалах, түүнийг зохиистой ашиглах орчин үеийн шаардлагатай танилцуулах гол зорилготой явагдаж байна. Сарын ажлын үеэр төрийн захиргааны болон анчдын нийгэмлэгийн байгууллага бүр сум орон нутгийнхаа байгаль түүний баялгийг танин мэдэх олон түмэнд баялгаа сурталчлах ажлыг суртал нэвтрүүлгийн бүх хэлбэрээр зохиох хэрэгтэй.

Ялангуяа пионер сурагчид, залуучуудад ой мод, ан амьтан, газартай харь-

цах ахмад үеийн уламжлалт заншлыг өвлүүлэн эзэмшүүлэх ажлыг сургууль, пионерийн байгууллага, эцэг эхчүүд онцгой анхаарвал зохино.

Байгалийн баялгийг зохиистой ашиглах асуудлаар олон нийтийг хамарсан сэдэвт кино, лекц, үзэшлэг, уулзалт зохиохын зэрэгцээ ой бэлчээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, модны үр цуглуулах, анд хужир мараа бэлтгэх, байгаль ашиглалтын холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтийн шалгалтанд делутат, идэвхтэн хөдөлмөрчид, пионер сурагчдыг өргөн оролцуулах нь чухал.

Сарын ажлын үеэр байгаль түүнийг нөөцийг арвижуулахтай холбогдсон төрөл бүрийн ажлыг сум хороод бүр өөрсдийн онцлогт тохируулан өргөн зохиохоос гадна нийт хөдөлмөрчдийн дунд байгаль хамгаалах ашиглах шинжлэх ухаан практикийн ойлголтын нийтлэг чанарыг өргөн дэлгэрүүлэх, сурталчилгаа судалгааны ажлыг нам, улс, олон нийтийн байгууллага, анчдын нийгэмлэгээс эрхлэн улам үр нөлөөтэй зохиох нь чухал байна.

# БНМАУ-ЫН ОЙН БАЙГУУЛЛАГЫН 50 ЖИЛИЙН ОЙД

## ОЙ-ХҮМҮҮС

ЗХУ болон бусад социалист орнууд байгалийг хамгаалах асуудлыг их анхаарал үзэж байна. Манай удмынхан эрт дээр үеэс эхлэн байгалиа дархан хамгаалсаар ирсэн түүхтэй. Хүний энэ сайхан зүтгэл нь өвөг дээдсээс үе уламжлан ирсэн заншлаар баялгийн санг хойч үедээ өвлөх хөрөнгө мөн ажээ. Ойд хүмүүс нэн хайртайг бид мэднэ. Энэ ойн цоорхойд суут эрдэмтэд үзэгдэл мөнхий хуулийг нээж, их хувьсгалд уриалан дуудсан зохиолуудаа бичихэд нь ойн шуугиан саад болоогүй! Ой, партизан цэргүүдийг орогноулж их хувьсгалд бэлтгэж байсныг Оросын Брянск, Бесраби

манай Тужийн нарс зэрэг газрууд мартаагүй. Дайны хүнд жилүүдэд ой дайчдыг тэтгэж байсан. Хусны шүүс унд болж, нарс хушны канифолоор хийлээ зүлгүүрдэн (Огневскийн полонезыг) тоглож, терпентинээр шархаан эмнэж явсан юм. Ой, дайнд бас шатаж хядагдаж дараа нь өсч үржиж ирлээ. Хувьсгал ялснаас хойш манай оронд нам, засгаас удаа дараалан авсан арга хэмжээний үрээр нийт ард түмний хөрөнгө болж ой маань зүй зохистой ашиглагдаж байна. Энэ хөрөнгө маань ойн фондын нийт талбайн 15 сая га, бүх нутгийн 10 хувийг эзэлдэг.

Модны бүх нөөцийг 1396,2 кубметр миллиард гэдэг. Тэгвэл дэлхийн нэг хүнд 0,5 га ойн талбай шаардагдана. Африкт нэг хүнд 0,19 га, Европт 0,2 га, манайд нэг хүнд 10-аас илүү га ноогдож байна. Нэг хүнд оногдох хэмжээгээр бол Финляндаас 3 дахин, ЗХУ-аас 4 дахин, АНУ-аас 7 дахин их юм. Дэлхийн олон улсад гаргаж байгаа сонин жил бүр 9 сая тонн цаасыг хэрэглэж байна. Үүнийг үйлдвэрлэх гол түүхий эд нь гацуур юм. Тэгвэл манайд шилмүүст ой 72,9 хувийг эзэлж байна. Ой хүний эрүүл мэнд урт удаан наслахын нэг нөхцөл нь болдог. Ууланд ургасан мод 500 наслахад хотод тарьсан хар мод 300 наслаж хүний төлөө энэ мод 200

насаа зориулжээ. Улаанбаатар хотын нэг хүн бүрт 6,6 шоо метр но гоон талбай ноогдож байна. Ийм учраас хүмүүс амьдралаа хамгаалдагийн адил ой мод, цэцэрлэгээ хайрлан хамгаалах үүрэгтэй юм. Ойд мөн гайхалтай сонин зүйлс зөндөө. Тухайлбал Калифорнид ургадаг Секвой гэдэг модыг 7 метрийн урт хөрөөгөөр 13 өдөр хөрөөдөж унагана. Ойн тухай яригдаж буй энэ үед гэртээ аваачъя гэвэл төмөр замын задгай 30 вагон шаардагдана. Хүрсэн хойноо тэр модныхоо хөндийд нь нэгдлийн нэг тракторыг хадгалан засвар хийх боломжтой юм. Мөн Дуглас гэдэг мод байдаг. Нэг ийм модоор

14 өрөөтэй байшинг барьсан удаа бий. «Секвой» хэрэв хараад ярьдагсан бол 100 метрийн өндрөөс 3500—4000 жилийнхээ амьдралыг 14 метр бүдүүн биеэр хүнгэнүүлэн хүүрнэхсэн. Хүмүүс ойтой харьцахад нийгмийн байдал хөгжил шууд нөлөөлдөнө. Иймд нэг хүний ухамсар асар их үүрэгтэй. Жишээ нь; АНУ-ын ойн үйлдвэрийн эзэд ой модоо хайр найргүй устгаж үйлдвэрүүд нь зай завсаргүй ойгоор хоолож төлөвлөгөө аричлгаа байхгүйгээс ойн ашигтай талбай нь жилээс жилд буурсаар байна. Зөвхөн арслан зааны мод 26-хан төгөл үлджээ. Ер нь ойгоо хайрлавал өөрийгөө хайрлана гэсэн үг.

Инженер Д. ЭРДЭНЭ

## ОЙ, АН ХАМГААЛАГЧ



Зураг дээр: Ой, ан хамгаалагч Лувсанцэрэн. ЗОХИОГЧ-ийн авсан гэрэл зураг.

Ай хөө Нахиу дээрээ намаржаатай Намрын гурван сард нь цөнгөлтэйхэн Өвөр дээрээ өвөлжөөтэй Өвлийн гурван сард нь өнтөйхөн байдаг Хажуу дээрээ -хаваржаатай Хаврын гурван сард нь жаргалтайхан Зулай дээрээ зуслантай Зуны гурван сард нь цөнгөлтэйхэн байдаг Ай хөө Харгайгийн нь бариад гаран гэхэд Халтар халиун буга нь бутардаг Хун цэн шувуу нь цөнгөлтэйхэн Хур цэцгийн шүүсэн ундаатайхан гэж Ухаант ард түмэн маань мянган мянган жил хайлсан аялгуут сайхан туульсынхаа утга уянга бүрийд нь эх нутгийнхаа гоо үзэмж эрэлхэг хөдөлмөрийнхөө жавхаа, энхрийлэн хайрласан сэтгэлийнхээ хайрыг шингээн дуулжээ. Алдар магтаал хөдөлмөр жаргалын өлгий-эх нутгийн минь нуур амгалан бол нугас амгалан билээ. Төр өлх нутгийнхаа амгалангийн харуул болсон ой-ан хамгаалагч өвгөн Лувсанцэрэн гуайтай сайхан уулзлаа. Өглөө морио эмээллэж, буугаа агсан, дурангаа өвөрлөж, ухуулгын материал, гоожин зөвшөөрөл өгөх бичиг бүхий цүмхээ үүрээд өнөө л уулын оргил, гацааны жим, туулын гарам гучин нэгэн жил явсан танил замаараа ажилдаа гарна. Лувсанцэрэн гуай гучин хоёр насандаа байгаль хамгаалагч болжээ. Байгаль хамгаалагч гэдэг амаргүй гэж энэ өвгөн ярина. Лувсанцэрэн гуай Баян даваанаас, Халзан хүртэл уртаашаа 60 км, Туулаас, Хоёр модны хяр хүртэл өргөшөө 20 км, 250 га дээвсгэр нутгийг хамгаалдаг. Миний хариуцсан

нутгийн 60 хувь нь ой мод бөгөөд 22 булаг устай, гөрөөс, туулай гээд 11 төрлийн антай, 16 өвөл жөө хаваржаа, 140-өөд өрх, 8900-гаад малтай гээд яах нийхний зуургүй тоочин тоолно. Энэ өвгөн бараг ойдоо хичнээн мод байдгийг, тэрч байтугай ямар мод хэд насалж буйг ч мэдэх байхаа. Энэ ч аргагүй юм. Ой мод гэгч эрүүл ахуйн фабрик төдийгүй байгалийн баялгийн том үйлдвэрлэлийг өөртөө явуулж байдаг. Энэ хүү баялгийг нэмэгдүүлэгч үйлдвэрлэлийг удирдагч гэж ой-ан хамгаалагчийг хэлж болох юм. Тэгээд ч Лувсанцэрэн гуай байгаль хамгаалагчын тал бүрийн ажлыг тусгасан жил, улирал, сар, өдрийн төлөвлөгөө зохион мөрдөж хийснээ тэмдэглэн ажилладаг хүн. Ингэж ажилласны дунд ой, ан агнуурын хууль зөрчих зөрчлийн тоо эрс цөөрч сүүлийн 10 гаруй жил хариуцсан нутгаас нь гал түймэр гараагүй байна. Улсаас өгсөн гоожин хураамжийн төлөвлөгөөг жил дараалан биелүүлж ирсэн бөгөөд 1950—1973 онд нийтдээ 217 мянга шахам төгрөгийг улсад оруулсан аж. Ажил үйлс бүхэн өөрийн алтан гартнаа алдаршуулагд. Эрдэнэ сумын ой-ан хамгаалагч Лувсанцэрэн гуай Ойн ажилчдын улсын анхдугаар зөвлөлгөөн, Усан замын ажилчдын анхдугаар зөвлөлгөөнд оролцож хөдөлмөрийн гавъяа нь улаан тугийн одон, 40, 50 жилийн ойн зэрэг хөд хэдэн медалиар шагнагд жээ. Энэ бүхэн бол түүний байгаль орчин-үү нутгаа хайрласан сэтгэл зүтгэлийнх нь үнэ цэнэ билээ. Ш. ЦЭРЭНДОО

## ТАВАН ЖИЛИЙН ГАВШГАЙЧИД

Аймгийн Ойн аж ахуйн модон эдлэлийн төвийн тасагт аймгийн 3 удаагийн аварга мужаан Н.Мижид, мужаан С. Агваан-Лувсан Н.Ядамсүрэн, Н.Цагаан нар тогтвортой амжилтаараа хамт олноо ямагт манлайлан ажилладаг. Тэд амласан амлалтаа биелүүлж сар улирал, жилийн төлөвлөгөөг тогтмол давуулснаар V таван жилийнхээ төлөвлөгөөг 1 жил 6 сарын өмнө 100,7—107,4 хувиар биелүүлсэн сайчууд юм. Төлөвлөгөөгөө ингэж биелүүлэхийн зэрэгцээ материалын өөдөс ашиглаж

дээрх хугацаанд мужаан тус бүр 450—500 төгрөгийн ашиг үйлдвэртээ оруулжээ. Тэдэнтэй уулзаж хэрхэн ажиллаж амжилтанд хүрсэн тухай нь асуухад ажлын бэлтгэлийг ажил эхлэхээс өмнө буюу орой ажил тарах үед хийж ажлын цагийн минут бүрийг үр бүтээлтэй ашиглаж чадвал амжилтанд хүрнэ. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулахын тулд хийх гэж буй зүйлийнхээ материалыг шилэн сонгож авахаас эхэлдэг гэж ярьж байна.

МАНАН СУРВАЛЖЛАГЧ



Баянзүрх сумын ой-ан хамгаалагч С.Сандагдорж энэ ажлыг 19 жил хийсэн туршлагатай хүн юм. Тэрээр гоожин хураамж, дагалт ашиглагчдын төлөвлөгөөг жил дараалан биелүүлж иржээ. Зураг дээр: Ой-ан хамгаалагч С. Сандагдорж ойн байлгийн тухай үзүүлэн таниулахдаа хүмүүст сурталчилж байна. Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг.

Шөнийн харанхуйг хөөх үүрийн цагаан гэгээний дараахан алтан нарны түмэн цацраг тэнгэрийн хаяаг зэсийн өнгөөр гэрэлтүүлэн гийгүүлэх ертөнцийн өглөө бүхэн сайхан. Инээд баясал ажил хөдөлмөр түмэн өнгийн дуу авиа яруу сайхан өнгө гэрлийн эхлэл нь чухамдаа л өглөө билээ.

Тэрхэн агшинд боссон айл нэг ч үгүй атал тэртэй зүүн хорооноос ажлын хөвөнтэй хүрэм өмсөж таван жингийн хүнд хүрз мөрөн дээрээ тавьсан нэгэн хүн хотын төв рүү алхаж явлаа.

Тэр хүн яван явсаар хотын төвд шинээр тавьж буй барагшин замын ханслага дэрлүүлэн хүрээ тавиад хөвөнтэй хүрмээ тайлаж харагдлаа.

Удалгүй хөнгөрч нимгэрсэн төмөр хүрээний хан хан хийх царгна дуу цуу райлаж хайрга чулуу сарр

сарр цацагдах чимээ өглөөний анир тайвныг эвдэн сонсогдож, энэ чимээнээр түрүүчийн айл босч шингэн цэнхэр утаа уулгүй тэнгэрт хээтэн бургилла.

Бүсгүйн барьж буй хүрз нарны гэрэлд нийлвэл толь мэт гялалзана. Энэ хотын өглөө ингэж эхэллээ.

Эгэл жирийн ажилчин бүсгүй төрж өссөн хотынхоо өглөөг зарлан дуудаж ирдэг юмуу даа. Намайг бүр дэргэд нь тулж очих үес бүсгүй эргэж хараа.

Урьд өмнө хэдэнтээ нүүр учирсан тандаг хүн байлаа. Хэн гэдэгсэн билээ. Энэ бүсгүйг Соёлын ордны тайзан дээр яруу сайхан хөгжмийн эгшингтэй хослох хоолойн цээлээр бүхний сэтгэлийг эзэмдэх тэрхэн мөчид би «Сайхан дуулж байна шүү» гэж хажуугийнхаа хүнд магтаж байсан удаа бий.

Тиймээ бүх ард түмний

урлагийн үзэлтэй энэ бүсгүй шалгарч байсан юмдаг. Хэн гэдэгсэн билээ...

Хүн бүхний сэтгэлд баар баясал, хийж бүтээхийн их хүслэн ундрүүлсан тэр нэгэн хурал дээр энэ бүсгүй шагнал авч байсан шүү дээ.

Шагнагдагсдын дотор хамгийн залуу нь энэ бүс

## ЗАМЧИН

Сурвалжилсан  
тэмдэглэл

гүй байсан. МХЗЭ-ийн Төв Хорооны «тэргүүний ажилчин залуу» алтан медаль энгэртээ гялалзуулан хурлын нндэр дээр гарч ирээд түүний хэлсэн үгийг би санаж байна. Бүх ард түмний социалист уралдааны жил-1973 оныхоо төлөвлөгөө 187,3 хувиар биелүүлж цагийн нормыг

4 хувиар хэмнэсэн гэж ярьсан шүү дээ.

Тойрон аялалынхныг үлэж мордуулах тэр нэгэн цуглаан дээр энэ бүсгүй бүрч баяртай явсан. Хэн гэдэгсэн билээ...

Залуу хүний хязгааргүй их хүсэл тэмүүлэл бадрангуй сэтгэлээр Соёлын ордны тайзан дээр дуучин болж, алсын замд аялагч болж, номын санд хэдэн цагаар сууж алдарт Горький, Пушкин, Насатдоржийн сонгодог уран бүтээлийн амтанд умбаж, шинэ кино үзэгч нь болж явдаг энэ бүсгүй хэдийд нь ийм их ажил хийж амжилт гаргадаг байна даа гэж бодож явлаа.

Энэ бүхний дотроос хайрга чулуу сарр сарр цацагдаж хөнгөрч нимгэрсэн төмөр хүрээний хан хан хийх чимээ ард минь тодхон сонсогдсоор байлаа.

Нэр уулсын оройгоос тасран хөөрч өглөөний ажилдаа яарсан түмэн тү-

жигнэж, буман бужигнаж машин тэрэг зөрөлдөн дахилдаж анир тайвныг эвдэнэ. Хүн хүнээс баярлаж хүн хүнээрээ бахархаж явах шиг сайхан юм энэ орчлонд үгүй билээ.

Тэр бүсгүйтэй би дахин уулзав.

Таван жилийнхээ ажлыг гурван жил зургаан сард багтаан хийсэн гэх сэтгэл хангалуун үгийг нь сонсож суух даа хүдэр чийрэг эрч гэлээ. Тийм амархан хийж барамгүй их зүйлийг энэ бүсгүй бүтээжээ гэж бахархаж сэтгэл аянлаа төрлөө.

Хамгийн сүүлд нь би түүнээс

—Нэр хэн билээ гэж асуув

—Дашдулам

—Нас хэд билээ.

Арванестэй. Энэ бүсгүй Тус аймгийн Зам ашиглагчтын ангийн ажилчин юм.

Д.РЕНЧИНДОРЖ

## АЖИЛЧНЫ АЛДАР НЭР

Сурвалжилсан

Зуунмод хотын Ойн аж ахуйн төвийн тасагт орвол хөрөө, алх, сүхний дуун үл тасалдан, хуш, хар мод, нарсны зоргодос цайран сэвсийг давирхай будагны үнэр ханхлан, мужаан эрчүүд чөлөө завгүй. Үйлдвэрийн мастер гэсэн өрөөнд ороход мастер Ичинхүү хүснэгтэн дээр тоо бөглөж, сампин тачигнуулан сарын эцсийн тайлангаа гаргаж сууна.

Мастер Ичинхүүгээс ойн байгууллагын 50 жилийн ой угтсан ажлаа ярьж өгнө үү? гэхэд.

—Манай модон тасаг 1974 оны социалист уралдааны жил, 458 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс эхний 8 сард жилийн үйлдвэрлэлийн 75,3 хувийг үйлдвэрлэж сар уурийн төлөвлөгөөг 120-130,7 хувиар биелүүлэв.

Манайд ажил төрлөөрөө шалгарсан тэргүүний сайчуул олон бий.

Тэднээс тус аймгийн ойн аж ахуйн модон эдлэлийн төвийн тасгийн тэргүүний мужаануудын нэг Н.Мижид үйлдвэрийн 5 удаагийн, аймгийн 3 удаагийн аварга хүндээ.

Тэр сүүлийн 6 жил дараалан төлөвлөгөөгөө 140-160-хувиар тогтмол биелүүлж 27 мянган төгрөгийн бүтээгдэхүүн төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэсэн юм. Аварга Н.Мижид V таван жилийн төлөвлөгөөг нэг жил зургаан сарын өмнө 107,4 хувиар биелүүлж, 1975 оныхоо ажилд орсон хүн.

Өнөө жил сар уурийн хаа төлөвлөгөөг 130-150 хувь биелүүлэн, энэ оны эхний 8 сарын хугацаанд

19,463 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1974 оны социалист уралдаанд хамт олноо хошуучилж яваа тэргүүний ажилчиндаа гэв.

Аймгийн 3 удаагийн аварга мужаан Н.Мижид: —Би энэ ажлыг 16 жил тасралтгүй хийж байна.

Ер нь ажилчин хүн цагийн нарийн баримталж хувийн төлөвлөгөө тооцоотой ажиллах нь чухал.

Маргааш хийх ажлыг урьд орой нь бэлтгэж юу хийхээ сайн тооцоолж, хийх юмныхаа материалыг сонгож авбал хийсэн бүтээгдэхүүн чанар сайтай болдог юм.

Ажилчин хүн ажил эхлэхээс өмнө 15-20 минутын өмнө ирж өдрийн хэрэгсэлээ бэлтгэж хийх зүйлийнхээ зураг төсөлтэй сайтар танилцаж, мод маань хуурай байна уу? энэ хийгдэх зүйлд тохирох уу? үгүй юу? гэдгийг сайн анхаарах нь чухал.

Зарим хүн гартаа дайралдсан материалаар хийснээр зарим мод нойтон, тахир, мурий, өө сэвтэй байснаас бүтээгдэхүүн го тогтодог.

Захиалгыг мастераас хүлээн авахдаа заавал зөвлөгөө авч түүнийхээ дагуу өөрөө зураг төслийг хийж ажилладаг.

Мужаан хүн юухнаар ч юм хийхийг бодох нь чухал. Модны өөдсөөр хүүхдийн тоглоом, ширээ санд дээрэг хүний хэрэгцээт зүйлийг хийж байвал ард түмний хэрэгцээ хангагдаг юм.

Ажилчин гэдэг эрхэм хүндэт нэрийг ээжийнхээ нэр шиг хайрлан хүндэтгэж арван зургаан жилийн хөдөлмөрөө мужааны ажилд зориулсан Н.Мижид хамт олны халуун дэмжлэг туслалцаатайгаар үйлдвэр, аймгийн алдар цуутнуудын нэг болсондоо бахархана.

Мужаан Н.Мижид түүний гэр бүл, үр хүүхдийг баярлуулсан сайхан үйл явдал болсон нь саяхан Ойн аж ахуйн Яамнаас аваргын хийж бүтээсэн хөдөлмөрийг өндрөөр үнэлж Яамны хүндэт дэвэрт бичжээ.

Түүний ярих нь: —Би 18 наснаасаа ажиллаж эхэлсэн.

Хашир туршлагатай хүмүүс, тэргүүний ажилчдын арга туршлагаас уйгагүй сурч ажилласан маань миний хоёр дахь багш гэж боддог юм гэж ярьж байв.

Н.Мижид олон арван шавьтай хүн. Шавь нар нь багшийнхаа алдрыг бас л өргөж явна.

Тэрээр залуу ажилчдад ямарч ажлыг хийсэн, түүндээ эзэн болж чаддаг байх хэрэгтэй. Аливаа ажлыг дагнан мэргэжиж тогтвортой ажиллавал амжилтанд хүрнэ.

Ахмад үеэсээ үргэлж суралцаж яваарай гэж заах дуртай ажээ. Н.Мижидийн хийсэн хорол эрдэнэ тооно, унь, хана, бат дэн хаалга, гэрийн болон конторын тавилга шүүгээ сав, авдар, ширээ, сандал хийсэн эзнийхээ алдрыг илчлэн байх шиг айл өрх, албан байгууллага бүрт харагдана. Ажилчин хүний алдар нэр ийнхүү бахархам ажээ.



## Хүүхдэд тавих анхаарал халамж

1974-1975 оны хичээлийн шинэ жилд аймгийн хэмжээгээр 2000 гаруй хүүхэд шинээр 1 дүгээр ангид элсэн орлоо.

Суралцдны хичээл сурлагын цаашдын амжилт нь 1 дүгээр ангид хөрхөн ямар суралцснаас ихээхэн шалтгаална.

Хүүхдийг тодорхой бэлтгэлгүй оруулснаас бага ангид эзэмшвэл зохих мэдлэг чадвар дадлагаг дутуу эзэмшиж цаашдаа сурлага авьяасаараа доголдох явдал гарч болдог.

Иймд шинээр суралцах хүүхдийг оюун санаа, хэл яриа, эрүүл мэнд, математикийн талаар бүрэн бэлтгэсэн байх шаардлагатай.

Юуны урьд эрдэм сурах бүрэн итгэлтэй, тохиолдох бэрхшээлийг давах тэвчээр хатуужилтай анхаараа төвлөрүүлж биеэ барих чадвар сайтай, ойр зуурын боловч үзэгдэл юмст үнэлэлт бүлгосон хийж чаддаг болгосон байх ёстой.

Үүний зэрэгцээгээр хэл ярианы хөгжилт шийдвэрлэх үүрэгтэй. Үр хүүхдэдээ онц анхаарал тавьдаггүй, тэдэнтэй тоож ярьдаггүй, асууж сонирхсон бага боловч зүйлд нь үнэн зөв хариулт тайлбар өгдөггүй ийм гэр бүлийн дотор өсөж хүмүүжсэн хүүхэд нь хэл ярианы хөгжилт муутай болдог.

Хүүхэд шинэ сонин зүйлс, үлгэр, оньсого, таавар зэргийг уншиж таал

гах нь уг хүүхдийн сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэхээс гадна үг ярианы баялагтай болгох сайн талтай.

Бага насны хүүхдийг хэт их эрхлүүлэх, хэзгий хэлснийг нь өгөөрлөж даамжруулснаас хэл гий ээрүү болдог.

Энэ нь ирээдүйд уг хүүхдийн хичээл сурлагад нөлөөлөд зогсохгүй сэтгэл санааны хувьд нь ч нөлөөлж гуньж гутрах байдалд хүргэдэг юм.

Сургуульд орсон бүх хүүхэд мэдлэгийг жинд эзэмшдэггүй нь олондлын шалтгаантай байдаг боловч зарим тохиолдолд хүүхдийг эрүүл мэндийн хувьд бэлтгээгүйгээс сурлагаар хоцрох явдал үзэгдсээр байна.

Зарим эцэг эхчүүд хүүхдээ архаг өвчтэй гэдэсний цагаан хорхойтой, мөн ангины өвчтэйг мэдсээр байж эмчлүүлэлгүй сургуульд оруулах нь аяндаа сурлагаар хоцрогдох муу талтай.

Ер нь хүүхдийг эрүүл байлгаж гол нөхцөл нь өдрийн дэглэмийг мөрдүүлж сургах явдал юм.

Хүүхдийн хэрэглээл зохих сурах бичиг болон бусад хичээлийн хэрэгсэл, өмсч хэрэглэх зүйлсийг шинээр бэлтгэж, түүнийг хайр гамтай, цэвэр ашигладаг намбай ажлаагаанд сургах талаас нь эцэг эхчүүд онцгой анхаарвал зохин.

Барш С.ТОЙВГОО

Н.НАНЖИД ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б.ЦЭРЭНДАШ

«Анхдугаар таван жил» сонин СХ-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.